

# ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Амгалан дулааны станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** САГ-2026/6/НА-СТА-ТӨҮГ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p> <p>Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Санхүү, нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг Утас: 51-261663 Цахим хаяг: <a href="mailto:naranchimegts@audit.gov.mn">naranchimegts@audit.gov.mn</a></p> <p>Аудитын менежер Б.Долгорсүрэн Утас: 51-260512 Цахим хаяг: <a href="mailto:dolgorsurenb@audit.gov.mn">dolgorsurenb@audit.gov.mn</a></p> <p>Ахлах аудитор С.Шийлэгмаа Утас: 51-261628 Цахим хаяг: <a href="mailto:shiilegmaas@audit.gov.mn">shiilegmaas@audit.gov.mn</a></p> <p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Ди Эй Би Жи Аудит ХХК-ийн захирал Н.Дэлгэрмаа Цахим хаяг: <a href="mailto:dabq.audit@gmail.com">dabq.audit@gmail.com</a></p>
------------------------------------------------------------------------------------------------------------	------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

<b>1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ</b> .....	3
<b>2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН</b> .....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	6
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан .....	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	8
2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан .....	9
2.5 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл .....	10
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА</b> .....	11
3.1 Компани, түүний үйл ажиллагаа .....	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .....	12
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл .....	13
3.6 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл .....	15
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН</b> .....	15
4.1 Ерөнхий зүйл .....	15
4.2 Материаллаг байдал .....	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	16
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хэрэгжилт .....	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	17
4.5.1 Завсрын аудитын талаар .....	17
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн .....	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	18
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ</b> .....	19
5.1 Албан шаардлага .....	19
5.2 Зөвлөмж .....	20
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b> .....	22

### Товчилсон үгийн жагсаалт

ААНБОАТ	Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвар
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АДС	Амгалан дулааны станц
АТҮТ	Авто тээврийн үндэсний төв
МУЕА	Монгол улсын Ерөнхий аудитор
МУЗГ	Монгол улсын Засгийн газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
ТБОНӨХБАУХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах
ТЕГ	Татварын ерөнхий газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
УБДС	Улаанбаатар дулааны сүлжээ
ЭХЯ	Эрчим хүчний яам



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.16 № 06/671  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ  
ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ М.МӨНХӨӨ ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Амгалан дулааны станц" ТӨХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв толилуулсан байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 183,808.4 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

1. Гүйцэтгэх захирлын 2025 оны А/149 дүгээр тушаалаар жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогод хамрагдсан албан тушаалтан, нэгжийн эд хөрөнгийн картуудыг гарын үсэг зурж баталгаажуулан аудитад ирүүлсэн ч нийт 179,171.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг дансаар, хөрөнгийн ангиллаар нэгтгэсэн тооллогын бүртгэл, тайлан, илтгэх хуудас ирүүлээгүй, тушаал шийдвэрийг хавсаргаагүй байгаа нь жилийн эцсийн тооллого хийсэн эсэхийг нотлох боломжгүй;
2. Авлага дансны үлдэгдэлд 14 байгууллага, хувь хүмүүсийн нийт 129.2 сая төгрөг, Өглөг дансны үлдэгдэлд 7 байгууллагын 3,530.1 сая төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй;
3. Мөнгөн хөрөнгийн зарлагын журналд 20 байгууллага, хувь хүний 318.8 сая төгрөгийн и-баримтаар баталгаажаагүй, анхан шатны баримтын бүрдүүлэлт дутуу ажил гүйлгээг бүртгэсэн

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 18 дугаар зүйлийн 18.1 “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 12 дугаар зүйлийн 12.1 “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна”, 20 дугаар зүйлийн 20.2.5 “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6 “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1 “Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь тооллого эхлэхээс өмнө өмч хамгаалалтад хяналт тавих үүрэг бүхий болон холбогдох мэргэжлийн хүмүүсийг оролцуулан Тооллогын комисс томилж байгуулна”, 72.4.1 “эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах” заалтуудтай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлангийн үнэн ба зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **Асуудлын онцлон тэмдэглэсэн хэсэг**

“Амгалан дулааны станц” ТӨХК нь усны нөөцийг хэмнэх, үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор Эм Си Эс Кока Кола ХХК-ийн үйлдвэрлэсэн цэвэршүүлсэн хаягдал усыг технологийн хэрэгцээнд дахин ашиглах төслийн хүрээнд 3,508.1 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг хандив тусламжаар хүлээн авсан байна.

### **Асуудлын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр санхүүжүүлсэн “Амгалан дулааны станцыг өргөтгөх Улаанбаатар хотын зүүн бүсийн дулааны эрчим хүчний хэрэглээний өсөлтийг хангах” төслийн хүрээнд бий болсон 279 нэрийн 68,415.5 сая төгрөгийн хөрөнгийг ТӨБЗГ-ын 2025 оны 612 дугаар тогтоол, Эрчим хүчний барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комиссын 2025 оны 07/2025 дүгнэлтийг тус тус үндэслэн Дуусаагүй барилга данснаас Үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлэн бүртгэж, тайлагнасан байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Эрчим хүчний зохицуулах хорооны 2025 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 59 дүгээр тогтоолоор “Амгалан дулааны станц” ТӨХК-ийн Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-д худалдах дулааны энерги болон чадлын тариф (НӨАТ-гүй)-ыг өөрчлөн 2025 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуусталх хугацаанд мөрдөхөөр баталсан байна.

## Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	<b>ХӨРӨНГӨ</b>		
1.1	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	410,120,632.41	6,118,166,807.55
1.1.2	Дансны авлага	35,682,590.19	8,134,192,009.92
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	428,504,220.89	931,358,220.05
1.1.4	Бусад авлага	11,649,963.56	6,864,688.56
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.6	Бараа материал	3,762,565,378.54	3,309,067,453.05
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	592,860,948.60	377,026,424.68
1.1.8	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>5,241,383,734.19</b>	<b>18,876,675,603.81</b>
1.2	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	56,766,384,306.06	126,104,795,921.92
1.2.2	Биет бус хөрөнгө	13,046,626,646.35	13,068,451,262.83
1.2.3	Хойшлогдсон татварын хөрөнгө	706,393,235.58	1,098,761,753.54
1.2.4	Бусад эргэлтийн бус хөрөнгө	61,785,119,475.62	1,652,790,587.00
1.2.5	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>132,304,523,663.61</b>	<b>141,924,799,525.29</b>
1.3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>137,545,907,397.80</b>	<b>160,801,475,129.10</b>
2	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
2.1.1	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	8,694,325,467.76	16,127,215,100.69
2.1.1.2	Цалингийн өглөг	1,142,567.91	-
2.1.1.3	Татварын өр	3,081,839,741.94	6,626,480,975.58
2.1.1.4	НДШ - ийн өглөг		48,780.00
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	2,449,536.57	-
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	85,446,347.58	85,545,347.74
2.1.1.9	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>11,865,203,661.76</b>	<b>22,839,290,204.01</b>
2.1.2	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.1	Урт хугацаат зээл	18,077,872,341.41	16,109,912,359.74
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	2,807,971,198.01	3,469,046,329.43
2.1.2.4	Бусад урт хугацаат өглөг	627,834,431.62	542,289,083.82
2.1.2.4	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>21,513,677,971.04</b>	<b>20,121,247,772.99</b>
2.2	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>33,378,881,632.80</b>	<b>42,960,537,977.00</b>
2.3	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч: а) төрийн	99,598,987,346.37	99,598,987,346.37
2.3.2	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	99,598,987,346.37	99,598,987,346.37
2.3.3	Эздийн өмчийн бусад хэсэг	13,005,849,600.00	13,005,849,600.00
2.3.4	Хуримтлагдсан ашиг	(11,002,016,586.86)	2,695,572,988.07
2.3.5	Өмнөх үеийн үр дүн	(11,002,016,586.86)	(10,975,157,031.03)
2.3.6	Тайлант үеийн үр дүн	-	13,670,730,019.10
2.3.7	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>104,167,025,765.00</b>	<b>117,840,937,152.10</b>
2.4	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>137,545,907,397.80</b>	<b>160,801,475,129.10</b>

**2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	<b>62,110,414,135.04</b>	<b>70,989,232,684.29</b>
2	Борлуулалтын өртөг	47,549,186,632.04	52,644,726,560.29
3	<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>14,561,227,503.00</b>	<b>18,344,506,124.00</b>
4	Түрээсийн орлого	1,479,677.42	-
5	Хүүний орлого	832,993.22	559,408.97
6	Эрхийн шимтгэлийн орлого	-	3,668,890,594.47
7	Бусад орлого	1,111,917,868.57	-
8	Орлогын дүн	1,114,230,539.21	3,669,450,003.44
9	Ерөнхий ба удирдлагын зардал	3,662,362,847.11	4,111,018,317.69
10	Санхүүгийн зардал	-	2,379,884,799.79
11	Бусад зардал	744,706,230.98	524,387,675.40
11.1	Задлын дүн	4,407,069,078.09	7,015,290,792.88
12	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>11,268,388,964.12</b>	<b>14,998,665,334.56</b>
13	Орлогын татварын зардал	1,402,979,789.27	1,327,935,315.46
14	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>9,865,409,174.85</b>	<b>13,670,730,019.10</b>
15	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>9,865,409,174.85</b>	<b>13,670,730,019.10</b>
16	Нийт дэлгэрэнгүй орлогын дүн	9,865,409,174.85	13,670,730,019.10

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	<b>74,443,572,622.89</b>	<b>70,066,487,348.86</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	73,213,371,216.63	70,015,056,273.53
1.1.2	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	15,053,061.00	30,265,779.00
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	1,070,121,900.00	-
1.1.4	Бусад мөнгөн орлого	145,026,445.26	21,165,296.33
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	<b>58,599,531,578.40</b>	<b>56,001,325,644.58</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	6,198,792,697.48	7,859,412,691.83
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1,935,733,094.95	2,362,764,501.78
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	23,052,078,050.27	25,963,216,785.09
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	11,167,944,383.58	7,541,992,235.04
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	4,609,909,500.00	5,350,279,303.40
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн	3,455,325,899.42	2,379,884,799.79
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	5,163,953,853.69	2,328,916,999.39
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	1,353,600.00	10,734,620.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	3,014,440,499.01	2,204,123,708.26
1.3	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>15,844,041,044.49</b>	<b>14,065,161,704.28</b>
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	<b>832,993.22</b>	<b>559,408.97</b>
2.1.2	Хүлээн авсан хүүгийн орлого	832,993.22	559,408.97
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	<b>5,418,450,947.00</b>	<b>3,150,206,748.44</b>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	5,418,450,947.00	3,150,206,748.44
2.3	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(5,417,617,953.78)</b>	<b>(3,149,647,339.47)</b>
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	<b>14,383,321,044.56</b>	<b>5,207,468,189.67</b>
3.2.1	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	14,383,321,044.56	5,207,468,189.67
3.3	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(14,383,321,044.56)</b>	<b>(5,207,468,189.67)</b>
5	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(3,956,897,953.85)</b>	<b>5,708,046,175.14</b>
6	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>4,367,018,586.26</b>	<b>410,120,632.41</b>
7	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>410,120,632.41</b>	<b>6,118,166,807.55</b>

**2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	-	-	-	-	-
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	9,196.00	9,196.00
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>99,598,987,346.37</b>	<b>2,559,125,684.08</b>	<b>13,005,849,600.00</b>	<b>(20,867,425,761.71)</b>	<b>94,296,536,868.74</b>
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	5,079,721.41	-	-	5,079,721.41
Тайлант үеийн цэвэр ашиг	-	-	-	9,865,409,174.85	52,522,501,771.66
<b>2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>99,598,987,346.37</b>	<b>2,564,205,405.49</b>	<b>13,005,849,600.00</b>	<b>(11,002,016,586.86)</b>	<b>104,167,025,765.00</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	26,859,555.83	26,859,555.83
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>99,598,987,346.37</b>	<b>2,564,205,405.49</b>	<b>13,005,849,600.00</b>	<b>(10,975,157,031.03)</b>	<b>104,193,885,320.83</b>
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг	-	-	-	13,670,730,019.10	13,670,730,019.10
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	(23,678,187.83)	-	-	(23,678,187.83)
<b>2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>99,598,987,346.37</b>	<b>2,540,527,217.66</b>	<b>13,005,849,600.00</b>	<b>2,695,572,988.07</b>	<b>117,840,937,152.10</b>

Амгалан дулааны станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд  
хийсэн аудитын тайлан

**2.5 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**  
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Х/н	2024 оны гүйцэтгэл	2025 он		Харьцуулалт			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	2024 гүйц/ 2025 гүйц	Хувь	2025 төл/ 2025 гүйц	Хувь
<b>Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт гол нэр төрлөөр:</b>			<b>1,041.1</b>	<b>1,157.7</b>	<b>1,100.3</b>	<b>59.2</b>	<b>105.6</b>	<b>(57.3)</b>	<b>95.0</b>
1	ДЭХ Дулааны сүлжээнд	м.төг	62,070,012.3	71,466,395.1	70,948,270.1	8,878,257.7	114.3	(518,125.0)	99.2
	ДЭХ Өөрийн түгээлт	м.төг	40,387.6	44,598.0	40,962.5	574.9	101.4	(3,635.4)	91.8
	Үйл ажиллагааны бус орлого	м.төг	250,500.0	191,000.0	3,669,452.7	3,418,952.7	1,464.8	3,478,452.7	1,921.1
	Татаас санхүүжилт	м.төг	863,747.1	-	-	(863,747.1)	-	-	-
2	<b>Нийт орлого</b>	<b>м.төг</b>	<b>63,224,647.1</b>	<b>71,701,993.1</b>	<b>74,658,685.3</b>	11,434,038.2	118.0	<b>2,956,692.2</b>	104.1
3	<b>Нийт зардал</b>	<b>м.төг</b>	<b>51,956,255.7</b>	<b>67,811,900.0</b>	<b>59,660,018.3</b>	7,703,762.6	114.8	<b>(8,151,881.6)</b>	87.9
	Түлшний зардал	м.төг	22,537,928.8	27,054,168.4	25,090,863.3	2,552,934.5	111.3	(1,963,305.1)	92.7
	Үйл ажиллагааны зардал	м.төг	12,031,593.7	16,541,267.8	15,505,888.5	3,474,294.8	128.8	(1,035,379.2)	93.7
	Худалдаж авсан ЦЭХ-ний өртөг	м.төг	8,454,201.6	12,996,279.9	10,727,152.8	2,272,951.1	126.8	(2,269,127.1)	82.5
	Бусад зардал /татвар, хүү/	м.төг	2,026,229.2	3,919,194.9	3,123,587.7	1,097,358.4	154.1	(795,607.2)	79.7
	Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	м.төг	6,745,792.3	7,054,758.9	4,986,555.5	(1,759,236.7)	73.9	(2,068,203.3)	70.6
	Удирдлагын зардал	м.төг	160,509.9	246,229.8	225,970.3	65,460.4	140.7	(20,259.4)	91.7
4	<b>Татварын өмнөх ашиг</b>	<b>м.төг</b>	<b>11,268,391.4</b>	<b>3,890,093.1</b>	<b>14,998,666.9</b>	3,730,275.5	133.1	<b>11,108,573.8</b>	385.5
5	<b>Цэвэр ашиг /алдагдал/</b>	<b>м.төг</b>	<b>9,865,409.1</b>	<b>2,395,143.4</b>	<b>13,670,730.0</b>	3,805,320.8	138.5	<b>11,275,586.6</b>	570.7
6	<b>Төсвийн төлбөрт нийт дүн</b>	<b>м.төг</b>	<b>7,003,500.0</b>	<b>1,643,542.4</b>	<b>8,136,017.9</b>	1,132,517.9	116.1	<b>6,492,475.4</b>	495.0
	а/ Орлогын татварт	м.төг	-	-	1,220,619.8	1,220,619.8	-	1,220,619.8	(100.0)
	б/ НӨТ	м.төг	4,158,900.0	-	3,447,285.0	(711,614.9)	82.8	3,447,285.0	(100.0)
	в/ НДШ	м.төг	1,939,600.0	1,348,526.7	2,363,023.6	423,423.6	121.8	1,014,496.9	175.2
	г/ Хүн амын орлогын татвар	м.төг	718,100.0	-	904,327.8	186,227.8	125.9	904,327.8	(100.0)
	д/ Үл хөдлөх хөрөнгийн татвар	м.төг	168,400.0	268,710.1	168,429.2	29.2	100.0	(100,280.8)	62.6
	ж/ Бусад татварт (улсын тэмдэгтийн хураамж)	м.төг	18,500.0	26,305.6	32,332.2	13,832.28	174.7	6,026.6	122.9
7	Төрийн өмчийн ногдол ашгийн өглөг	м.төг	-	-	-	-	-	-	-
8	Нийт ажиллагсдын тоо	хүн	217.0	217.0	215.0	(2.0)	99.0	(2.0)	99.0
9	Нийт цалингийн сан	м.төг	7,389,021.0	9,591,625.5	9,357,182.7	1,968,161.7	126.6	(234,442.7)	97.5
10	Нэг ажиллагчийн дундаж цалин	м.төг	2,837.5	3,683.4	3,626.8	789.2	127.8	(56.6)	98.4
11	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	м.төг	0.84	0.95	0.84	-	100.0	(0.1)	88.4
12	Хөрөнгө оруулалт	м.төг	1,716,500.0	2,482,000.0	2,416,979.9	700,479.9	140.8	(65,020.0)	97.3
13	<b>Нийт авлага</b>	<b>м.төг</b>	<b>346,059.7</b>	<b>566,300.0</b>	<b>9,072,414.9</b>	<b>8,726,355.1</b>	<b>2,621.6</b>	<b>8,506,114.9</b>	<b>1,602.0</b>
	Үүнээс: Найдваргүй	м.төг	-	-	-	-	-	-	-
14	<b>Нийт өглөг</b>	<b>м.төг</b>	<b>33,378,881.6</b>	<b>22,200,000.0</b>	<b>42,960,537.9</b>	<b>9,581,656.3</b>	<b>128.7</b>	<b>20,760,537.9</b>	<b>193.5</b>
	Богино хугацаат өр төлбөр	м.төг	11,865,203.6	-	22,839,290.2	10,974,086.5	192.4	22,839,290.2	(100.0)
	Урт хугацаат өр төлбөр	м.төг	21,513,677.9	22,200,000.0	20,121,247.7	(1,392,430.2)	93.5	(2,078,752.2)	90.6

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Компани, түүний үйл ажиллагаа

“Амгалан дулааны станц” ТӨХК нь орчин үеийн дэвшилтэт технологиор эрчим хүчний системийн найдвартай ажиллагааг хангах гэж эрхэм зорилгоо тодорхойлсон байна.

Компанийн дүрэмд хэрэглэгчдийг дулааны эрчим хүчээр тасралтгүй, найдвартай хангах, эдийн засгийн үр ашигтай ажиллах үндсэн зорилтыг тодорхойлсон байна.

Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл нь дулааны эрчим хүч үйлдвэрлэж, хэрэглэгчдийг дулааны эрчим хүчээр хангах ажил үйлчилгээ байна.

“Амгалан дулааны станц” ТӨХК нь 100 хувь төрийн өмчит хаалттай хувьцаат компани бөгөөд нийт хувьцааны 66.0 хувийн төлөөллийг Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, 34.0 хувийн төлөөллийг “Эрчист монгол” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани тус тус хэрэгжүүлж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор ТУЗ-ийн ажиллах журмыг батлан мөрдөж байна. ТУЗ-ийн 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 26 дугаар тогтоолоор компанийн 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтын ажлын төлөвлөгөө, 2025 оны 19 дүгээр тогтоолоор Гүйцэтгэх захиралтай онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг байгуулан ажиллаж байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

“Амгалан дулааны станц” ТӨХК нь Компанийн тухай хууль, Эрчим хүчний тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон бусад хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдөн ажилладаг.

Тайлант хугацаанд компанийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Үйлдвэрчний эвлэлийн хороотой байгуулсан 2025-2026 онд хэрэгжих Хамтын гэрээ
- Эрчим хүчний зохицуулах хорооны 2025 оны 59 дүгээр тогтоолоор дулааны энерги болон чадлын тарифыг шинэчлэн баталсан

Компанийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Компани дотоод аудитын ажилтангүй. ТУЗ-ийн аудитын хороо тайлант онд хөрөнгө оруулалтын санхүүжилт, зарцуулалт, худалдан авах ажиллагааны хэрэгжилт, зэрэг чиглэлээр 15 төрлийн ажлыг төлөвлөж, 3 дугаар улирлын байдлаар 12 ажлыг 93.8 хувьтай гүйцэтгэсэн тайланг ирүүлсэн.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Амгалан дулааны станц” ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

“Амгалан дулааны станц” ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын 2022 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн А/115 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн компанийн үйл ажиллагааны онцлогт тохируулан шинэчлэн боловсруулж, гүйцэтгэх захирлын 2026 оны А/01 дугаар тушаалаар батлан мөрдөж байна.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

“Амгалан дулааны станц” ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 23,255.6 сая төгрөгөөр буюу 14.5 хувиар өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	410.1	6,118.2	5,708.0
Дансны авлага	475.8	9,072.4	8,596.6
Бараа материал	3,762.6	3,309.1	(453.5)
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	592.9	377.0	(215.8)
Үндсэн хөрөнгө	69,813.0	139,173.3	69,360.3
Хойшлогдсон татварын хөрөнгө	706.4	1,098.8	392.4
Бусад эргэлтийн бус хөрөнгө	61,785.1	1,652.8	(60,132.3)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>137,545.9</b>	<b>160,801.5</b>	<b>23,255.6</b>
Богино хугацаат өр төлбөр	11,865.2	22,839.7	10,974.5
Урт хугацаат өр төлбөрийн дүн	21,513.7	20,121.2	(1,392.4)
Өр төлбөрийн нийт дүн	33,378.9	42,960.5	9,581.7
Өмч: Төрийн	99,599.0	99,599.0	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	2,564.2	2,540.5	(23.7)
Эздийн өмчийн бусад хэсэг	13,005.9	13,005.8	(0.0)
Хуримтлагдсан ашиг	(11,002.0)	2,695.6	13,697.6
Эздийн өмчийн дүн	104,167.0	117,840.9	13,673.9
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>137,545.9</b>	<b>160,801.5</b>	<b>23,255.6</b>

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, дансны авлага, татвар, нийгмийн даатгалын авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, бусад эргэлтийн бус хөрөнгө, богино хугацаат өр төлбөр, урт хугацаат өр төлбөр, эздийн өмчийн данснуудад өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан байна. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 6,118.2 сая төгрөг болж 5,708.1 сая төгрөгөөр өссөн нь УБДС ТӨХК-аас гэрээт дулааны орлогын төлбөр 2025 оны 12 дугаар сарын 30, 31-ний өдрүүдэд хагаслан орж ирсэнтэй холбоотой;
2. Дансны авлагын үлдэгдэл 9,072.4 сая төгрөг болж 8,596.5 сая төгрөгөөр өссөн нь УБДС ТӨХК-аас жилийн эцсийн байдлаар 8,127.3 сая төгрөгийн борлуулалтын авлага үүссэн нь голлон нөлөөлсөн, мөн Татвар, НДШ-ийн авлага дансны үлдэгдэл 931.3 сая төгрөг болж 502.8 сая төгрөгөөр өссөн нь хэрэгжээгүй НӨАТ-ын авлагаас шалтгаалсан;

3. Бараа материал дансны үлдэгдэл 3,309.1 сая төгрөг болж 453.5 сая төгрөгөөр буурсан нь нүүрсний үлдэгдэл өмнөх оноос 627.9 сая төгрөгөөр буурч, хангамжийн материалын үлдэгдэл 174.4 сая төгрөгөөр өссөнтэй холбоотой;
4. Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 126,104.8 сая төгрөг болж 69,338.4 сая төгрөгөөр өссөн нь тайлант оны худалдан авалт 2,390.4 сая төгрөг, ТӨБЗГ-ын 2025 оны 612 дугаар тогтоолоор шийдвэрлэсэн Хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр санхүүжүүлсэн “Амгалан дулааны станцыг өргөтгөх Улаанбаатар хотын зүүн бүсийн дулааны эрчим хүчний хэрэглээний өсөлтийг хангах” төслийн хүрээнд бий болсон 279 нэрийн 68,415.5 сая төгрөгийн хөрөнгийг Дуусаагүй барилга данснаас, Эм Си Эс Кока Кола ХХК-ийн үйлдвэрлэсэн цэвэршүүлсэн хаягдал усыг технологийн хэрэгцээнд дахин ашиглах төслийн хүрээнд 3,508.1 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг Хандив, тусламжийн орлогоор тус тус бүртгэн нэмэгдүүлж, ТӨБЗГ-ын 2025 оны 572 дугаар тогтоолоор шийдвэрлэсэн 107 нэрийн 1,378.5 сая төгрөгийн ашиглалтын шаардлага хангахгүй болсон үндсэн хөрөнгийг акталж, данснаас хассан, тайлант оны элэгдлийн зардлын өөрчлөлт 3,597.1 сая төгрөгөөр тус тус хасагдуулснаас шалтгаалсан;
5. Бусад эргэлтийн бус хөрөнгө дансны үлдэгдэл 1,652.8 сая төгрөг болж 60,132.3 сая төгрөгөөр буурсан нь тайлант оны санхүүжилт 8,283.1 сая төгрөгөөр нэмэгдэж, Эрчим хүчний барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комиссын 2025 оны 07/2025 дүгнэлт, ТӨБЗГ-ын 2025 оны 612 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Дуусаагүй барилга данснаас 68,415.5 сая төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгөнд шилжүүлэн бүртгэсэнтэй холбоотой;
6. Богино хугацаат өр төлбөр 22,839.3 сая төгрөг болж 10,974.1 сая төгрөгөөр өссөн нь жилийн эцэст татвар, цахилгаан эрчим хүч, нүүрс, бусад өглөг дансны өрийг төлөөгүй нь нөлөөлсөн;
7. Урт хугацаат өр төлбөр 20,121.3 сая төгрөг болж 1,392.4 сая төгрөгөөр буурсан нь санхүү татварын зорилгоор байгуулсан үндсэн хөрөнгийн элэгдлийн зөрүүгээр 661.1 сая төгрөгөөр нэмэгдэж, урт хугацаат санхүүгийн түрээс 2,053.5 сая төгрөгөөр буурснаас шалтгаалсан;
8. Эздийн өмч дансны үлдэгдэл 117,840.9 сая төгрөг болж 13,673.9 сая төгрөгөөр өссөн тайлант оны цэвэр ашиг байна.

### **3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу “Амгалан дулааны станц” ТӨХК нь үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө/техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Эрчим хүчний сайдын 2025 оны А/22 дугаар тушаалаар тус компаний 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг тодотгон баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 71,699.5 сая төгрөгөөр, нийт зардлыг 71,499.4 сая төгрөгөөр, 200.1 сая төгрөгийн ашигтай ажиллахаар баталсан байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 2,487.0 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Эрчим хүчний сайдын 2025 оны 10 дугаар сард А/272 дугаар тушаалаар тус компаний 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг тодотгон, нийт зардлыг 67,811.9 сая төгрөгөөр, 3,887.6 сая төгрөгийн ашигтай ажиллахаар баталж, хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 2,482.0 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 74,658.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 59,660.0 сая төгрөгийн зардал гарган, 14,998.7 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан байна.

### **Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин**

Нийт орлогын гүйцэтгэл 74,658.7 сая төгрөг болж төлөвлөснөөс 2,956.7 сая төгрөг буюу 4.1 хувиар давсан нь 51.0 мянган Гкал дулаан эрчим хүч дутуу түгээсэнтэй холбоотой 519.3 сая төгрөгийн борлуулалтын орлогын төлөвлөгөө тасарч, Эм Си Эс Кока Кола ХХК-ийн 3,508.1 сая төгрөгийн хандив тусламжийн орлоготой холбоотой үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 3,487.5 сая төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Нийт зардлын гүйцэтгэл 59,660.0 сая төгрөг болж, төлөвлөснөөс 8,151.9 сая төгрөг буюу 12.0 хувиар дутуу зарцуулсан байна. Энэ нь түлшний зардал 1,963.3 сая төгрөг, шатахууны зардал 175.6 сая төгрөг, цахилгааны ашиглалтын зардал 2,269.1 сая төгрөг, үндсэн ба нэмэгдэл цалингийн зардал 457.0 сая төгрөг, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал 2,068.2 сая төгрөгөөр хэмнэсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 32 төрлийн 129 нэрийн ажилд өөрийн эх үүсвэрээс 2,417.0 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд цэвэр ашиг 13,670.7 сая төгрөг болж, төлөвлөснөөс 11,275.6 сая төгрөгөөр илүү байгаа нь үйл ажиллагааны бус орлогын давсан гүйцэтгэл 3,487.5 сая төгрөг, нийт зарлагын 8,151.9 сая төгрөгийн дутуу зарцуулалт нөлөөлжээ.

### **СУДАЛГААНЫ ҮР ДҮН:**

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас судалгаа авч, үр дүнг тусгалаа. Үүнд:

*1. Байгууллагын орон тооны цомхотголын талаар:*

Монгол улсын хөгжлийн 2026 оны жилийн төлөвлөгөөнд заасан орон тоо бууруулах чиглэл, төсвийн зардлыг хязгаарлах, хэмнэх зорилтын дагуу тусгайлан 9 хувийн цомхотгол хийгээгүй;

*2. Унаа, хоолны хөнгөлөлтийн зардлын тарифын талаар:*

2025 оны 6 дугаар сарын 23-ны өдөр байгуулсан 2025-2026 онд хэрэгжүүлэх Хамтын гэрээний 4 дүгээр зүйлийн 4.7, 6 дугаар зүйлийн 6.2 дугаар заалтыг үндэслэн ажилтнуудын унааны нэмэгдлийг өдөрт 3,000.00 төгрөг, хоолны нэмэгдлийг үйлдвэрийн ажилчид 9,000.00 төгрөг, бусад ажиллагсдыг 7,000.00 төгрөгөөр тооцож олгохоор баталсныг мөрдсөн. Тайлант онд унаа, хоолны хөнгөлөлт 133.6 сая төгрөг зарцуулсан;

*4. Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой гарсан зардлын талаар:*

Өмнөх оны аудитаар 151/АО150092 төлбөрийн актаар сахилгын шийтгэл ногдуулсан 8 ажилтанд үр дүнгийн урамшуулалт цалин олгосон буруу шийдвэрт тогтоосон 9.2 сая төгрөг төлбөрийн актыг ҮАГ-т хугацаанд нь төвлөрүүлсэн. 2025 оны 70-11 дүгээр саруудад холбогдох ажилтнуудын цалингаас суутгал хийж байгууллагын хохирлыг бүрэн барагдуулсан байна;

*5. Сургалт, семинар, хурал, зөвлөгөөний судалгааны үр дүнгийн талаар:*

Тайлант онд ажил олгогч, удирдах ажилтны сургалтад 15, нийт ажилтны сургалтад 171, галын дохиоллын сургалтад 25, шинэ ажилтны сургалтад 27, нийт 233 ажилтан хамрагдаж 120.4 сая төгрөгийг зарцуулсан;

*6. Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан ажил, үйлчилгээний гэрээний талаар:*

Эрчим хүч & engineering мэргэжлийн сэтгүүл захиалгад 2.5 сая төгрөг, өөрийн компанийн веб сайт хөгжүүлэхэд 3.5 сая төгрөг, тарифын шинэчлэлийн агуулга, зорилтыг олон нийтэд сурталчлан таниулахад 99.8 сая төгрөг, нийт 105.8 сая төгрөгийг хэвлэл мэдээллийн зардалд зарцуулсан. Тарифын сурталчилгааг 5 компанид шууд худалдан авах гэрээгээр салгаж 99.8 сая төгрөг зарцуулсан зөрчилд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн.

### 3.6 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

“Амгалан дулааны станц” ТӨХК-ийн 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд батлагдсан ажил 43, бараа 58, нийт 101 нэр төрлийн арга хэмжээг 100.0 хувь зохион байгуулж, төсөвт өртгөөс 427.8 сая төгрөгийн хэмнэлттэй ажилласан байна.

#### Хүснэгт 2. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлт

/сая төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөөний		Гүйцэтгэлийн			Зөрүү	
		тоо	дүн	тоо	дүн	хувь	тоо	дүн
1	Ажил	43	2,741.6	43	2,603.6	95.0	-	138.0
2	Бараа	58	36,491.1	58	36,201.2	99.2	-	289.9
<b>Дүн</b>		<b>101</b>	<b>39,232.7</b>	<b>101</b>	<b>38,804.8</b>	<b>98.9</b>	<b>0</b>	<b>427.9</b>

Тайлант онд 23 удаагийн нээлттэй тендер шалгаруулалт, 27 удаагийн харьцуулалтын арга, 51 удаагийн шууд гэрээ байгуулах аргаар, нийт 101 удаагийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээ байгуулсан байна.

#### Хүснэгт 3. Худалдан авах ажиллагааны хэрэгжилт

/сая төгрөгөөр/

№	Худалдан авалт	Төлөвлөгөөний		Гүйцэтгэлийн			Зөрүү	
		Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Хувь	Тоо	Мөнгөн дүн
1	Нээлттэй тендер шалгаруулалт	23	36,531.8	23	36,272.8	99.3	-	259.0
2	Харьцуулалт	27	1,731.3	27	1,658.0	95.8	-	73.3
3	Шууд худалдан авалт	51	969.6	51	874.0	90.1	-	95.6
<b>Дүн</b>		<b>101</b>	<b>39,232.7</b>	<b>101</b>	<b>38,804.8</b>	<b>98.9</b>	<b>-</b>	<b>427.9</b>

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Амгалан дулааны станц ТӨХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн “Амгалан дулааны станц” ТӨХК, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн компанийн үйл ажиллагааг сайжруулах үйлдвэрчний эвлэлийн хорооны даргад хамтын гэрээнд тусгагдаагүй нэмэгдэл цалин олгосонтой холбоотой хамтын гэрээ, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг “Ди Эй Би Жи” Аудит ХХК-ийн аудитор Ө.Ундармаа, С.Цэнгэлмаа, мэргэжилтэн Ө.Гантулга нар гүйцэтгэж, захирал Н.Дэлгэрмаа, чанарын хяналтын менежер Д.Эрдэнэчимэг нар анхан шатны чанарын хяналтыг, Санхүүгийн аудитын газрын аудитор С.Шийлэгмаа, аудитын менежер Б.Долгорсүрэн, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

“Амгалан дулааны станц” ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2026 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 01/53 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

## 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2025 оны Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний баталсан төлөвлөгөөний орлогын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг тооцохдоо FAS програмд Орлого үр дүнгийн тайлангийн 3 дугаар улирлын байдлаарх нийт орлогын дүнг андуурч сонгосон тул жилийн эцэст материаллаг байдлыг шинэчлэн тогтоолоо.

Жилийн эцэст материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2025 оны жилийн эцсийн Орлогын дэлгэрэнгүй тайлан, суурь үзүүлэлтээр нийт орлогын дүнг сонгосон. Нийт орлогын 74,658.7 сая төгрөгийн 1.0 хувиар тооцож, материаллаг байдлыг 746.6 сая төгрөгөөр тогтоолоо.

## 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага 2025 оны зорилтот түвшинд 67,811.9 сая төгрөгийн нийт зардал батлуулан, 59,660 сая төгрөг гүйцэтгэлтэй буюу 12.0 хувиар зардлыг бууруулж, 8,151.8 сая төгрөгийн хэмнэлттэй ажилласан.

### Хамтын гэрээний талаар

Үйлдвэрчний эвлэлийн хороотой 2023-2024 онд хэрэгжүүлэх хамтын гэрээний 3 дугаар зүйлийн 3.8-д “Шөнийн цагаар ажилласан ажилтанд тухайн ажилтны дундаж цалин хөлсийг 50 хувиар тооцож үндсэн цалин дээр нэмэгдэл хөлс олгоно” гэж заасан нь Хөдөлмөрийн тухай хуулийн заалттай нийцэхгүй байгаа зөрчлийг арилгах өмнөх аудитын албан шаардлагыг 2025 онд шинэчлэн байгуулсан Хамтын гэрээний 3.8 дахь заалтад “сарын ажлын үр дүнгийн нэмэгдэл хөлсийг үндсэн цалин болох цаг зэргийн тарифт цалингийн 50 хүртэл хувиар дүгнэж журмын дагуу олгоно” гэж шинэчлэн баталсан байна.

## 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн шилэн дансны цахим хуудсанд тайлан, мэдээ хугацаа хоцроож оруулсан зөрчилд зөвлөмж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нээлттэй тендер шалгаруулах арга хэмжээг шууд худалдан авалт хийсэн зөрчилд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлжээ.

### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны цахим хуудсанд нийт 180 мэдээ оруулахаас Дараа жилийн зорилтот түвшин, Хагас жилийн санхүүгийн тайлан, Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ зэрэг 3 мэдээ тайланг хугацаа хоцроон мэдээлсэн.

Энэ нь Шилэн дансны тухай хууль 4.1.1-т “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд тогтмол шуурхай оруулж байх”, МУЕА-ын 2021 оны А/108 дугаар тушаалаар батлагдсан журмын 3.1.7-д “хавсралт дахь мэдээлсэн байдлын хэрэгжилтийн дундаж 80-95 хувьтай бол зөвлөмж өгөх” гэсэнтэй тус тус нийцээгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, мэдээллийг тогтоосон хугацаанд бүрэн байршуулах зөвлөмж өгсөн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжтой нийцээгүй байна гэж дүгнэлээ.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хэрэгжилт

**Илрүүлэлт:** Нээлттэй сонгон шалгаруулалт, харьцуулалтын аргаас зайлсхийж, худалдан авах ажиллагаа зохион байгуулахгүйгээр төсөвт өртгийг 5 хуваан “Огмент” ХХК, “Майнример” ХХК, “Визлис визард” ХХК, “Блейк стар альфа” ХХК, “Энх ансмент” ХХК-тай шууд гэрээ байгуулж, нийт 99.8 сая төгрөгийг шилжүүлж, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.” Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай 5 дугаар зүйлийн 5.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална”, 10 дугаар зүйлийн 10.3-т “Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно.” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Нээлттэй сонгон шалгаруулалт, харьцуулалтын аргаас зайлсхийж, худалдан авах ажиллагаа зохион байгуулахгүйгээр төсөвт өртгийг хувааж, шууд гэрээ байгуулсан, өмнөх аудитын албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан албан тушаалтанд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлсэн.

Тайлант онд хийгдсэн худалдан авах ажиллагааг батлагдсан төлөвлөгөөний дагуу хуулийн хүрээнд хэрэгжүүлсэн эсэхийг тендерийн анхан шатны баримт материалтай тулган шалгасан ба Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, санхүүгийн тайлангийн эхний үлдэгдлээр авлага, өглөг, татварын дансдын эхний үлдэгдэл, тайлант онд нэмэгдсэн хөрөнгө, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, шилэн дансны хуулийн хэрэгжилт, мөнгөн хөрөнгийн зарлагын гүйлгээний анхан шатны баримтын бүрдүүлэлтэд горим, сорил хэрэгжүүлсэн.

Завсрын аудитаар 1,516.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс алдаа, зөрчил арилаагүй 906.9 сая төгрөгийн 2 зөвлөмжийг албан шаардлага, 99.8 сая төгрөгийн 1 зөрчлийг хариуцлага тооцох албан шаардлагаар жилийн эцэст аудитын тайланд тусгасан.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар нийт 7 алдаа, зөрчил илэрснээс 9.2 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 167.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах 3 албан шаардлага хүргүүлж, 1.7 сая төгрөгийн 3 зөвлөмж өгсөн. Гүйцэтгэх захирлын 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 01/214 дүгээр тушаалаар өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх төлөвлөгөөг ҮАГ-т хүргүүлсэн.

Жилийн эцсийн аудитаар шалгагдагч байгууллага биелэлтийн тайланг нотлох баримт материалын хамт ирүүлснийг хяналтын болон нарийвчилсан горим, сорил гүйцэтгэж, үнэлсэн. Үүнд: 9.2 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 67.9 сая төгрөгийн 2 албан шаардлага, 1.7 сая төгрөгийн 3 зөвлөмж бүрэн хэрэгжсэн, 99.8 сая төгрөгийн 1 албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчил давтагдсан тул холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	тоо	дүн	тоо	дүн	хувь
Зөвлөмж	3	1.7	3	1.7	100.0
Албан шаардлага	3	167.7	2	67.9	66.6
Төлбөрийн акт	1	9.2	1	9.2	100.0
<b>Нийт дүн</b>	<b>7</b>	<b>178.6</b>	<b>6</b>	<b>78.8</b>	<b>89.0</b>

Бүрэн хэрэгжээгүй албан шаардлагын талаар:

- Нээлттэй тендер шалгаруулалт, харьцуулалтын аргаар худалдан авалтыг зохион байгуулахаас зайлсхийсэн зөрчил нь арилаагүй, тайлант онд давтан гаргасан 99.8 сая төгрөгийн зөрчилд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус компанийн хойшлогдсон татварын хөрөнгө, хойшлогдсон татварын өр төлбөрийн бүртгэл, үндсэн хөрөнгийн элэгдлийн тооцооллыг нягтлан бодох бүртгэлийн бодлоготой уялдуулан нарийвчлан шалгах.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 183,808.4 сая төгрөгийн 5 зөрчил<sup>1</sup> илэрснээс үйлдвэрчний хорооны даргад хамтын гэрээнд заагаагүй нэмэгдэл урамшуулалт цалин олгосон нийт 8.7 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгч, мөнгөн хөрөнгийн зарлагын ажил гүйлгээ анхан шатны баримтын бүрдүүлэлтгүй зарцуулсан, авлага, өглөгийн дансны үлдэгдэл тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй тайлагнасан, татварын өр төлбөрийг татварын цахим сайтын тодорхойлолттой тулган үнэн зөв тайлагнаагүй, жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг дансаар, хөрөнгийн ангиллаар нэгтгэсэн тооллогын нэгдсэн бүртгэл, тооллогын тайлан илтгэх хуудас ирүүлээгүй, тушаал шийдвэрийг хавсаргаагүй, нийт 183,799.8 сая төгрөгийн 4 албан шаардлага хүргүүлсэн.

Аудитаар илэрсэн 183,808.4 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон 746.6 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

### 5.1 Албан шаардлага

**Илрүүлэлт 1.** Мөнгөн хөрөнгийн зарлагын журналд 20 байгууллага, хувь хүний 318.9 сая төгрөгийн и-баримтаар баталгаажаагүй, анхан шатны баримтын бүрдүүлэлт дутуу ажил гүйлгээг бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрийн өмчит хуулийн этгээд нь анхан шатны бүртгэлийн баталгаажсан баримтыг үндэслэн дэлгэрэнгүй болон хураангуй бүртгэл хөтлөн, тайлан тэнцлийг улирлаар зохиож, Сангийн яаманд тушаана” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Анхан шатны баримтын бүрдүүлэлт дутуу, и-баримтаар баталгаажаагүй ажил гүйлгээг бүртгэсэн зөрчлийг таслан зогсоож, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

**Илрүүлэлт 2.** Авлага дансны үлдэгдэлд 8 байгууллага, хувь хүмүүсийн 9.5 сая төгрөг, Урьдчилж төлсөн зардал дансанд 6 байгууллагын 119.6 сая төгрөг, нийт 129.2 төгрөгийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй; Өглөг дансны үлдэгдэлд 7 байгууллагын 3,530.1 сая төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д “Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрийн өмчит хуулийн этгээд нь анхан шатны бүртгэлийн баталгаажсан баримтыг үндэслэн дэлгэрэнгүй болон хураангуй бүртгэл хөтлөн, тайлан тэнцлийг улирлаар зохиож, Сангийн яаманд тушаана” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Авлага, өглөгүүдийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, барагдуулах тодорхой арга хэмжээ аваагүй зөрчлийг арилгаж, цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**Илрүүлэлт 3.** Тайлант оны нэмэгдсэн өртгийн албан татварыг 343.3 сая төгрөгөөр дутуу, аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварыг 91.0 сая төгрөгөөр, хувь хүний орлогын албан татварыг 215.4 сая төгрөгөөр тус тус илүү тайлагнаж, Татварын албатай тооцоо нийлж, баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, 20.2.7-д “аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах”, Төрийн болон орон нутгийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрийн өмчит хуулийн этгээд нь анхан шатны бүртгэлийн баталгаажсан баримтыг үндэслэн дэлгэрэнгүй болон хураангуй бүртгэл хөтлөн, тайлан тэнцлийг улирлаар зохиож Сангийн яаманд тушаана” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Татварын тооцооллыг анхан шатны баримт, бүртгэлд үндэслэн тооцоолж, татварын цахим системд хүсэлт илгээн залруулаагүй, зөрүүтэй тайлагнасан зөрчлийг арилгаж, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

**Илрүүлэлт 4.** Гүйцэтгэх захирлын 2025 оны А/149 дүгээр тушаалаар хийсэн жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогод хамрагдсан албан тушаалтан, нэгжийн эд хөрөнгийн картуудыг гарын үсэг зурж баталгаажуулан аудитад ирүүлсэн боловч 61,739.4 сая төгрөгийн барилга, 115,096.8 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж, 1,425.7 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл, 437.1 сая төгрөгийн тавилга эд хогшил, 472.8 сая төгрөгийн компьютер, бусад хэрэгслийг дансаар, хөрөнгийн ангиллаар нэгтгэсэн тооллогын бүртгэл, тайлан, илтгэх хуудас ирүүлээгүй, тушаал шийдвэрийг хавсаргаагүй байгаа нь жилийн эцсийн тооллого хийсэн эсэхийг нотлох боломжгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1-т “Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь тооллого эхлэхээс өмнө өмч хамгаалалтад хяналт тавих үүрэг бүхий болон холбогдох мэргэжлийн хүмүүсийг оролцуулан Тооллогын комисс томилж байгуулна”, 72.4.1-т “Тооллогын комисс эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Тооллогод хамрагдсан эд хөрөнгийг дансаар, хөрөнгийн ангиллаар нэгтгэсэн тооллогын бүртгэл хийгээгүй, тайлан, илтгэх хуудсаар баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

## **5.2 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**Хамтын гэрээ, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх:**

### **1. Нэмэгдэл цалин хөлс олгох:**

**Илрүүлэлт:**

Тайлант онд Үйлдвэрчний эвлэлийн хорооны даргад компаниас нэмэгдэл урамшууллыг бодож нийт 26,969.4 мянган төгрөг олгосон. Үүнээс амралтын цалин 2,999.6 мянга, зэргийн нэмэгдэл 2,640.5 мянга, хоол, унаа 700.0 мянга, бусад нэмэгдэл 8,658.5 мянган төгрөг олгосон.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20.4 "үйлдвэрийн газрын захиргааны бүтцийг тогтоож, албан тушаалтныг томилох, чөлөөлөх, эрх бүхий байгууллагаас тогтоосон цалингийн бүдүүвч сангийн хэмжээнд багтаан цалинг тогтоох", "Амгалан дулааны станц" ТӨХК-ийн Захиргаа, Үйлдвэрчний эвлэлийн хороотой 2026 оны 06 дугаар сарын 23-ний өдөр байгуулсан 2025-2026 онд хэрэгжүүлэх "Хамтын гэрээ"-ний 9 дүгээр зүйлийн 9.3.1-д "Сар, жилийн үр дүнгийн урамшуулал", 9.3.3-т "Удаан жилийн нэмэгдлийг Эрчим хүчний салбарт 2-оос доошгүй жил ажилласан бол ажилласан жилээр тооцон олгоно" гэсэн заалттай тус тус нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн , нэмэгдэл цалин хөлсийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн тооцож олгох, цаашид зөрчлийг давтан гаргахгүй ажиллах.

Дээрх албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Амгалан дулааны станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд  
хийсэн аудитын тайлан

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

Дд	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Мөнгөн хөрөнгийн зарлагын журналын ажил гүйлгээг анхан шатны баримттай тулган шалгахад 20 байгууллага, хувь хүний 318,893.0 мянган төгрөгийн И-баримт баталгаажуулаагүй, анхан шатны баримтын бүрдүүлэлт дутуу байна.	1	318.8			1	318.8				
2	Авлага дансны үлдэгдэлд 8 байгууллага, хувь хүмүүсийн 9,581.2 мянган төгрөг, Урьдчилж төлсөн зардал дансанд 6 байгууллагын 119,653.7 мянган төгрөг, нийт 129,235.0 мянган төгрөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй тайлагнасан. Өглөг дансны үлдэгдэлд 7 байгууллагын 3,530,153.0 мянган төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй тайлагнасан.	1	3,659.3			1	3,659.3				
3	Санхүүгийн тайлангийн татварын өр төлбөрийн үлдэгдлийг татварын тодорхойлолттой тулгахад НӨАТ 343,309.6 мянган төгрөгөөр дутуу, ААНБОАТ 91,028.9 мянган төгрөг, ХХОАТ 215,460.1 мянган төгрөгөөр тус тус илүү зөрүүтэй байна. Татварын албатай тооцоо нийлж баталгаажуулаагүй.	1	649.7			1	649.7				
4	Тайлант онд Үйлдвэрчний эвлэлийн хорооны даргад компаниас нэмэгдэл урамшууллыг бодож нийт 26,969.4 мянган төгрөг олгосон байна. Үүнээс амралтын цалин 2,999.6 мянган төгрөг зэргийн нэмэгдэл 2,640.5 мянган төгрөг, хоол, унаа 700.0 мянган төгрөг, бусад нэмэгдэл 8,658.5 мянган төгрөг олгосон нь Амгалан дулааны станц ТӨХК-ийн Захиргаа, Үйлдвэрчний эвлэлийн хороотой 2026 оны 06 дугаар сарын 23-ний өдөр байгуулсан 2025-2026 онд хэрэгжүүлэх "Хамтын гэрээ"-ний 9 зүйлийн 9.3.1 Сар, жилийн үр дүнгийн урамшуулал, 9.3.3 Удаан жилийн нэмэгдлийг ЭХ-ний салбарт 2-оос доошгүй жил ажилласан бол ажилласан жилээр тооцон олгон" гэсэн заалттай нийцээгүй байна.	1	8.6					1	8.6		

**Амгалан дулааны станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд  
хийсэн аудитын тайлан**

5	Захирлын 2025 он А/149 тоот тушаалаар жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого хийсэн байна. Аудитад тооллогод хамрагдсан албан тушаалтан, нэгжийн эд хөрөнгийн картуудыг гарын үсэг зурж баталгаажуулан ирүүлсэн, 61,739,404.9 мянга төгрөгийн барилга, 115,096,853.7 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 1,425,720.9 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 437,111.4 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 472,845.9 мянган төгрөгийн компьютер, бусад хэрэгсэлийг дансдаар, хөрөнгийн ангиллаар нэгтгэсэн тооллогын нэгдсэн бүртгэл, тооллогын тайлан илтгэх хуудас ирүүлээгүй, Тушаал шийдвэрийг хавсаргаагүй.	1	179,171.9			1	179,171.9				
<b>Дүн</b>		<b>5</b>	<b>183,808.4</b>		<b>-</b>	<b>4</b>	<b>183,799.8</b>	<b>1</b>	<b>8.6</b>	<b>-</b>	<b>-</b>

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/сая төгрөгөөр/

Дд	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
1	Шилэн дансны цахим хуудсанд нийт 180 мэдээ оруулахаас Дараа жилийн зорилтот түвшин, Хагас жилийн санхүүгийн тайлан, Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ зэрэг 3 мэдээ тайланг хугацаа хоцроон мэдээлсэн нь 98.2 хувийн гүйцэтгэлтэй байна.	1	-						1	-
Бусад хууль тогтоомжийн хэрэгжилт										
2	Нээлтэй сонгон шалгаруулалт, харьцуулалтын аргаас зайлсхийж, худалдан авах ажиллагаа зохион байгуулахгүйгээр 5 хуваан шууд гэрээ байгуулж, “Огмент” ХХК, “Майнример” ХХК, “Визлис визард” ХХК, “Блейк стар альфа” ХХК, “Энх ансмент” ХХК-д тус бүр 19,960.0 мянган төгрөгийг шилжүүлж, нийт 99,800.0 мянган төгрөгийн гэрээг 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдөр байгуулсан байна. Нээлтэй сонгон шалгаруулалт, харьцуулалтын аргаас зайлсхийсэн, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.	1	99.8			1	99.8			
<b>Дүн</b>		<b>2</b>	<b>99.8</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>99.8</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 555/А0150092

Улаанбаатар хот

САГ-2026/6/НА-СТА-ТВА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Амгалан дулааны станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Гүйцэтгэх захирлын 2025 оны А/149 дүгээр тушаалаар хийсэн жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогод хамрагдсан албан тушаалтан, нэгжийн эд хөрөнгийн картуудыг гарын үсэг зурж баталгаажуулан аудитад ирүүлсэн боловч 61,739,404,927.00 /Жаран нэгэн тэрбум долоон зуун гучин есөн сая дөрвөн зуун дөрвөн мянга есөн зуун хорин долоон/ төгрөгийн барилга, 115,096,853,781.00 /Нэг зуун арван таван тэр бум ерэн зургаан сая найман зуун тавин гурван мянга долоон зуун наян нэгэн/ төгрөгийн машин тоног төхөөрөмж, 1,425,720,902.00 /Нэг тэрбум дөрвөн зуун хорин таван сая долоон зуун хорин мянга есөн зуун хоёр/ төгрөгийн тээврийн хэрэгсэл, 437,111,492.00 /Дөрвөн зуун гучин долоон сая нэг зуун арван нэгэн мянга дөрвөн зуун ерэн хоёр/ төгрөгийн тавилга эд хогшил, 472,845,947.00 /Дөрвөн зуун далан хоёр сая найман зуун дөчин таван мянга есөн зуун дөчин долоон/ төгрөгийн компьютер, бусад хэрэгслийг дансаар, хөрөнгийн ангиллаар нэгтгэсэн тооллогын бүртгэл, тайлан, илтгэх хуудас ирүүлээгүй, тушаал шийдвэрийг хавсаргаагүй байгаа нь жилийн эцсийн тооллого хийсэн эсэхийг нотлох боломжгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1-т “Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь тооллого эхлэхээс өмнө өмч хамгаалалтад хяналт тавих үүрэг бүхий болон холбогдох мэргэжлийн хүмүүсийг оролцуулан Тооллогын комисс томилж байгуулна”, 72.4.1-т “Тооллогын комисс эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.2-т “хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй”-д гэж заасныг үндэслэн тус тус **ШААРДАХ нь:**

1. Тооллогод хамрагдсан эд хөрөнгийг дансаар, хөрөнгийн ангиллаар нэгтгэсэн тооллогын бүртгэл хийгээгүй, тайлан, илтгэх хуудсаар баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Амгалан дулааны станц ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал /М.Мөнхөө/, Ерөнхий нягтлан бодогч /Б.Оюунчимэг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ДИ ЭЙ БИ ЖИ АУДИТ ХХК  
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
Б.ДОЛГОРСҮРЭН

Н.ДЭЛГЭРМАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 556/АД150092

Улаанбаатар хот

САГ - 2026/6/НА - СТА - ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Амгалан дулааны станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны нэмэгдсэн өртгийн албан татварыг 343,309,667.00 /Гурван зуун дөчин гурван сая гурван зуун есөн мянга зургаан зуун жаран долоон/ төгрөгөөр дутуу, аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварыг 91,028,923.00 /Ерэн нэгэн сая хорин найман мянга есөн зуун хорин гурван/ төгрөгөөр, хувь хүний орлогын албан татварыг 215,460,118.00 /Хоёр зуун арван таван сая дөрвөн зуун жаран мянга нэг зуун арван найман/ төгрөгөөр тус тус илүү тайлагнаж, Татварын албатай тооцоо нийлж, баталгаажуулаагүй байна.


Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", 20.2.7-д "аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах", Төрийн болон орон нутгийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрийн өмчит хуулийн этгээд нь анхан шатны бүртгэлийн баталгаажсан баримтыг үндэслэн дэлгэрэнгүй болон хураангуй бүртгэл хөтлөн, тайлан тэнцлийг улирлаар зохиож Сангийн яаманд тушаана" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Татварын тооцооллыг анхан шатны баримт, бүртгэлд үндэслэн тооцоолж, татварын цахим системд хүсэлт илгээн залруулаагүй, зөрүүтэй тайлагнасан зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Амгалан дулааны станц ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал /М.Мөнхөө/, Ерөнхий нягтлан бодогч /Б.Оюунчимэг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ДИ ЭЙ БИ ЖИ АУДИТ ХХК  
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
Б.ДОЛГОРСҮРЭН

Н.ДЭЛГЭРМАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 557/АД150092

Улаанбаатар хот

САГ-2026/6/НА - СТА - ТВА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Амгалан дулааны станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Авлага дансны үлдэгдэлд 8 байгууллага, хувь хүмүүсийн 9,581,223.00 /Есөн сая таван зуун наян нэгэн мянга хоёр зуун хорин гурван/ төгрөг, Урьдчилж төлсөн зардал дансанд 6 байгууллагын 119,653,777.00 /Нэг зуун арван есөн сая зургаан зуун тавин гурван мянга долоон зуун далан долоон/ төгрөг, нийт 129,235,000.00 /Нэг зуун хорин есөн сая хоёр зуун гучин таван мянган/ төгрөгийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй,
- Өглөг дансны үлдэгдэлд 7 байгууллагын 3,530,153,081.00 /Гурван тэрбум таван зуун гучин сая нэг зуун тавин гурван мянга наян нэгэн/ төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй байна.


Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрийн өмчит хуулийн этгээд нь анхан шатны бүртгэлийн баталгаажсан баримтыг үндэслэн дэлгэрэнгүй болон хураангуй бүртгэл хөтлөн, тайлан тэнцлийг улирлаар зохиож, Сангийн яаманд тушаана" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7-д "авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Авлага, өглөгүүдийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, барагдуулах тодорхой арга хэмжээ аваагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Амгалан дулааны станц ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал /М.Мөнхөө/, Ерөнхий нягтлан бодогч /Б.Оюунчимэг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ДИ ЭЙ БИ ЖИ АУДИТ ХХК  
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
Б.ДОЛГОРСҮРЭН

Н.ДЭЛГЭРМАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 558/АД150092

Улаанбаатар хот

САГ - 2026/6/КА - СТА - ТӨА

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Амгалан дулааны станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Мөнгөн хөрөнгийн зарлагын журналд 20 байгууллага, хувь хүний 318,893,052.00 /Гурван зуун арван найман сая найман зуун ерэн гурван мянган тавин хоёр/ төгрөгийн и-баримтаар баталгаажуулаагүй, анхан шатны баримтын бүрдүүлэлт дутуу ажил гүйлгээг бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрийн өмчит хуулийн этгээд нь анхан шатны бүртгэлийн баталгаажсан баримтыг үндэслэн дэлгэрэнгүй болон хураангуй бүртгэл хөтлөн, тайлан тэнцлийг улирлаар зохиож, Сангийн яаманд тушаана" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Анхан шатны баримтын бүрдүүлэлт дутуу, и-баримтаар баталгаажуулаагүй ажил гүйлгээг бүртгэсэн зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Амгалан дулааны станцын гүйцэтгэх захирал /М.Мөнхөө/, Ерөнхий нягтлан бодогч /Б.Оюунчимэг/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ДИ ЭЙ БИ ЖИ АУДИТ ХХК  
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
Б.ДОЛГОРСҮРЭН

Н.ДЭЛГЭРМАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 613/А0111371

Улаанбаатар хот

САН-2026/6/НА-СТА-ТӨА

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд “Амгалан дулааны станц” ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нээлттэй сонгон шалгаруулалт, харьцуулалтын аргаас зайлсхийж, худалдан авах ажиллагаа зохион байгуулахгүйгээр төсөвт өртгийг 5 хуваан “Огмент” ХХК, “Майнример” ХХК, “Визлис визард” ХХК, “Блейк стар альфа” ХХК, “Энх ансмент” ХХК-тай шууд гэрээ байгуулж, нийт 99,800,000.00 /Ерэн есөн сая найман зуун мянган/ төгрөгийг шилжүүлж, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.” Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай 5 дугаар зүйлийн 5.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална”, 10 дугаар зүйлийн 10.3-т “Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно.” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т “Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.2-т “Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд “Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага” хүргүүлнэ” гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нээлттэй сонгон шалгаруулалт, харьцуулалтын аргаас зайлсхийж, худалдан авах ажиллагаа зохион байгуулахгүйгээр төсөвт өртгийг хувааж, шууд гэрээ байгуулсан, өмнөх аудитын албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан "Амгалан дулааны станц" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал /М.Мөнхөө/-д хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 2026 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Эрчим хүчний яамны сайд /Б.Чойжилсүрэн/-д даалгав.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:



С.МАГНАЙСҮРЭН